

## 8.4.5. Суралцагч хөтөлбөр шилжүүлэх


Суралцагчийг буруу курс, дамжаанд бүртгэсэн, суралцагч курс дамжаа ахисан, буурсан тохиолдолд үе шат шилжүүлэх үйлдлээр зөв курс, дамжаанд нь оруулна.

Суралцагч хөтөлбөр шилжүүлэх үйлдлийг дараах дарааллаар хийнэ. **Үүнд:**

1. **Суралцагч** ерөнхий цэсийг сонгоно.
2. Суралцагчийн дэд хэсгээс **жагсаалтийг** сонгоно.
3. Мэдээлэл засах суралцагчийн нэрний урд байрлах сонголтоос **хөтөлбөр шилжүүлэх** сонгоно.
4. Сургалтын хөтөлбөр шилжүүлэх цонхны мэдээлэл оруулаад **хадгалах** товч дарна.

Суралцагч хөтөлбөр шилжүүлэх үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Суралцагч** ерөнхий цэсийг сонгоно.



2. Суралцагчийн дэд хэсгээс **жагсаалтийг** сонгоно.

The screenshot shows the DBUMS system interface. The 'Суралцагч' (Student) section is active, and the 'Жагсаалт' (List) button is highlighted with a red border. The interface displays a table of student records.

#	Регистр	Эцэг/эхийн нэр	Нэр	Хөтөлбөр	Хөтөлбөрийн код	Суралцагчийн түвшин	Төлөв	Харъяаллын хаяг	Оршин суугаа хаяг	Хү
1	ух85082003	Мөнхжаргал	Мөнхцэцэг	Санхүү	041201	1-р дамжаа	Суралцаж байгаа	Улаанбаатар, Баянзүс	Улаанбаатар, Чингэлт	Эм
2	ф687081213	Баянмөнх	Наранбат	Санхүү	041201	2-р дамжаа	Суралцаж байгаа			Эр
3	ед80041363	Даваацэрэн	Мөнхзаяа	Газрын тосны инженер - Гадаад	072404 - Гадаад	1-р дамжаа	Суралцаж байгаа			Эм
4	нь03321618	Батбаатар	Батсүрэн	Газрын тосны инженер - Гадаад	072404 - Гадаад	1-р дамжаа	Суралцаж байгаа	Төв, Лүн, 2-р баг, Өгөө		Эр

### 3. Мэдээлэл засах суралцагчийн нэрний урд байрлах сонголтоос **хөтөлбөр шилжүүлэх** сонгоно.

Суралцагч

#	Регистр	Эцэг/эхийн нэр	Нэр	Хөтөлбөр	Хөтөлбөрийн код	Суралцагчийн түвшин	Төлөв	Харъяаллын хаяг	Оршин суугаа хаяг	Хү
1	ух85082003	Мөнхжаргал	Мөнхцэцэг	Санхүү	041201	1-р дамжаа	Суралцаж байгаа	Улаанбаатар, Баянзүс	Улаанбаатар, Чингэлт	Эм
	ф687081213	Баянменх	Наранбат	Санхүү	041201	2-р дамжаа	Суралцаж байгаа			Эр
	ед80041363	Даваацэрэн	Мөнхзаяа	Газрын тосны инженер - Гадаад	072404 - Гадаад	1-р дамжаа	Суралцаж байгаа			Эм
	ны03321618	Батбаатар	Батсүрэн	Газрын тосны инженер - Гадаад	072404 - Гадаад	1-р дамжаа	Суралцаж байгаа	Төв, Лүн, 2-р баг, Өгөө		Эр

### 4. Сургалтын хөтөлбөр шилжүүлэх цонхны мэдээлэл оруулаад **хадгалах** товч дарна.

Сургалтын хөтөлбөр шилжүүлэх

**Хадгалах** Каах

**Мөнхжаргал Мөнхцэцэг**  
TK11  
100000040106787 / ух85082003  
Суралцаж байгаа

Сургууль: bagshin surguli  
Хөтөлбөр: Санхүү  
Төлөвлөгөө: Санхүү 2021-2022  
Түвшин: 1-р дамжаа

Боловсролын түвшин: Бакалаврын боловсрол  
Сургалтын ээлж: Өдрийн сургалт  
Сургалтын ачаалал: Үндсэн (Бүтэн цаг)  
Сургалтын хугацаа: 4 жил / 128 кр

**Үйлдлийн мэдээлэл**

Үйлдэл: Хөтөлбөр шилжүүлэх  
Огноо: 2023/03/30

\* Шалтгаан:

**Шилжих сургалтын хөтөлбөр**

Сургууль: bagshin surguli  
Хичээлийн жил: 2020-2021 хичээлийн жил  
Олгох боловсролын зэрэг: Улирал  
Мэргэжлийн чиглэл: 1-р семестр  
Сургалтын хөтөлбөр: 2020/09/01  
Сургалтын төлөвлөгөө: Элсэлтийн төрөл  
Сургалтын ээлж: Элсэлтийн эх сурвалж  
Сургалтын ачаалал: Сонгон шалгарууллага  
Сургалтын хугацаа: жил / кр  
Суралцагчийн түвшин: 1-р дамжаа  
Удирдагч багш: Элсэлтийн байршил  
Тушаал/Шийдвэр: Дугаар ... 2023/03/30

### Тайлбар:

- Хэрэв суралцагчийн төлөв шинэ бол үе шат хооронд шилжүүлэх үйлдлээр хийхгүй суралцагчийн профайлын суралцагчийн хөтөлбөрийн мэдээлэл хэсгээр орж үе шатыг сольж хадгална.
- Суралцагчийг буруу үе шатанд бүртгээд баталгаажуулах хүсэлт илгээсэн бөгөөд хүлээгдэж байгаа төлөвтэй бол суралцагч цуцлах үйлдэл хийсний дараа суралцагчийн профайлын суралцагчийн хөтөлбөрийн мэдээлэл хэсгээр орж үе шатыг сольж хадгална.
- Суралцагч төгссөн төлөвтэй үед үе шат шилжүүлэх боломжгүй байна.
- Суралцагч суралцаж байгаа төлөвтэй бол үе шат шилжүүлэх үйлдэл хийж, баталгаажуулах хүсэлт илгээхэд ДБУМС шалгуур шалгаж хангасан тохиолдолд шилжүүлсэн үе шатанд суралцаж байгаа төлөвтэй болно.

Хөтөлбөрийн үе шат шилжүүлэх үйлдлийн цонхны тайлбар:

No.	Талбар Үйлдлийн мэдээлэл	Тайлбар	Жишээ
		Ямар нэгэн үйл ажиллагааг систем дээр үйлдлээр бүртгэнэ. Үйлдэл нь үйлдэл, шалтгаан, үйлдлийн огноо, өөрчлөлтийн дугаар, үйлдэл хийж буй хэрэглэгч, өөрчлөлтийн системийн огноо зэргээс бүрдэнэ. Үйлдлийн мэдээллийг дараа нь ямар шалтгаанаар, хэзээ, ямар хүн энэ үйлдлийг хийсэн гэдэг түүхийг харуулахад ашиглана.	
1.	Үйлдэл	Үйлдлийн төрлийг сонгоно.	Үе шат шилжүүлэх
2.	Шалтгаан	Энэ үйлдлийг хийж байгаа шалтгааныг сонгоно.	Шалгуур хангасан
3.	Огноо	Энэ үйлдлийг бодит амьдрал дээр хийсэн огноог оруулна.	2018/09/01
4.	Өөрчлөлтийн дугаар	Анх удаа бүртгэл хийж байгаа үед өөрчлөлтийн дугаар нь 1 байна. Дахин давтаж мэдээлэл өөрчилсөн үйлдэл хийсэн тохиолдолд энэ дугаар нь ихэснэ. Систем автоматаар дугаарлана. Хэрэглэгч гараас мэдээлэл оруулахгүй. Засах боломжгүй байна.	1
5.	Хэрэглэгч	Үйлдлийг хийж байгаа хэрэглэгчийн нэр харагдана. Засах боломжгүй байна.	User: МУИС-сургалтын алба
6.	Өөрчлөлтийн огноо	Үйлдэл хийж байгаа огноог систем автоматаар харуулна. Засах боломжгүй байна.	2018/09/02
	Шилжих үе шатны мэдээлэл		
1.	Сургууль	Суралцагчийн харьяалагдах салбар, бүрэлдэхүүн сургууль сонгогдсон байна. Засах боломжгүй байна.	Бизнесийн сургууль
2.	Сургалтын хөтөлбөр	Сургалтын хөтөлбөр сонгогдсон байна. Засах боломжгүй байна.	Санхүүгийн хөтөлбөр

No. 3.	Талбар Сургалтын төлөвлөгөө	Тайлбар Сургалтын төлөвлөгөө сонгогдсон байна. Засах боломжгүй байна.	Жишээ 2018-02
-----------	--------------------------------	--	------------------